

**ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ**

Д/д	Хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин	Биелэлт
1	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;	Төлөвлөгөөний тоо	1	1	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан баталсан.
2	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шалгаж, дүгнэлт гаргах;	Дүгнэлтийн тоо	Тухай бүр	2	2024 оны 03 дугаар сарын 04-ний өдөр Монгол Улсын Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төвд иргэн С.Нямдаваагаас Нийслэл хариуцсан хэлтсийн үйлчилгээний ажилтантай холбоотой гомдол ирүүлснийг тус газрын Ёс зүйн дэд хороонд шилжүүлсний дагуу хуулийн хугацаанд шийдвэрлэж ажилласан. хороо 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдөр Дархан-Уул аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн дарга Н.Соёлмаатай холбоотой гомдол тус хэлтсийн үйлчилгээний ажилтан Н.Нармандахаас ирүүлснийг хянан холбогдох журмын дагуу шийдвэрлэж дүгнэлт хүргүүлсэн.
3	Байгууллага, нэгж дотор гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан, нөхцөл, эрсдэлийг тооцох, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор судалгаа хийх;	Судалгааны тоо	2	1	Нийт албан хаагчдын дунд байгууллага, нэгж дотор гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан, нөхцөл, эрсдэлийг тооцох, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор судалгаа авч үр дүнг нэгтгэн удирдлагад танилцуулсан. Тус судалгаанд нийт 116 албан хаагч хамрагдаж байгууллагын дотоод уур амьсгал, үүсэж байгаа болон ирээдүйд үүсэж болзошгүй ёс зүйн зөрчил, эрсдэлийг

					тодорхойлон холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.
4	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, ажлын тайлан, мэдээг гаргаж Ёс зүйн хороонд хүргүүлэх;	Тайлангийн тоо	2	1	2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны I улирлын тайланг хүргүүлсэн. 06 дугаар сарын 21-ний өдөр II улирлын тайланг хүргүүлсэн.
5	Ёс зүйн зөрчил гаргасан талаар гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэх хурлыг тухай бүрд нь зохион байгуулах.	Хянан шийдвэрлэсэн гомдол мэдээллийн тоо	Тухай бүр	2	Орхон аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн үйлчилгээний ахлах ажилтантай холбоотой 1, Нийслэл хариуцсан хэлтсийн үйлчилгээний ажилтантай холбоотой 1, нийт 2 гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж холбогдох албан хаагчид мэдэгдэл хүргүүлсэн бөгөөд Орхон аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн үйлчилгээний ахлах ажилтан өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөж Нийслэл хариуцсан хэлтсийн үйлчилгээний ажилтантай холбоотой гомдлыг ээлжит хурлаар хэлэлцэн шийдвэрлэж Ёс зүйн дэд хорооны хурлын дүгнэлтийг холбогдох албан тушаалтан, гомдол ирүүлсэн этгээд, гомдолд холбогдогч этгээдэд хүргүүлж ажилласан.
6	Байгууллагын албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн талаарх хууль тогтоомжийг таниулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах	Сургалтын тоо	2	1	Төрийн албаны зөвлөл, Ёс зүйн хорооноос 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдөр хамтран зохион байгуулсан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хүрээнд “Төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн төслийг танилцуулах сургалтад байгууллагын нийт албан хаагчдыг хамруулсан.
7	Шинээр ажилд орсон албан хаагчдад ёс зүйн асуудлаар сургалт зохион байгуулахад холбогдох нэгжтэй хамтран ажиллах	Сургалтын тоо	8	4	Захиргаа удирдлагын газрын хүний нөөцийн мэргэжилтэн, ахлах мэргэжилтэнтэй хамтран байгууллагад шинээр томилогдсон нийт албан хаагчид ёс зүйн асуудлаар 3 удаагийн сургалт зохион байгуулж зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан.

8	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, шийдвэрлэлтийн талаар олон нийтэд тогтмол мэдээлэх;	Мэдээллийн тоо	5	2	Байгууллагын албан ёсны цахим хуудаст Ёс зүйн дэд хороо байгуулах тушаал, 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Ёс зүйн дэд хорооны ажиллах журам, зөрчил гаргасан талаар 2 гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэсэн талаар олон нийтэд мэдээлж ажилласан.
9.	Иргэд, байгууллагын албан хаагчдыг мэдээллээр хангах, арга зүйн зөвлөгөө өгөх.	Зөвлөгөө мэдээллийн тоо	4	2	Төрийн албан хаагчийн ёс зүй, Ёс зүйн дэд хорооны ажиллах журмыг танилцуулах сургалтыг зохион байгуулж нийт албан хаагчдад зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Мөн гомдол ирүүлсэн 1 иргэнд шийдвэрлэлтийн талаарх мэдээлэл өгч дүгнэлтийг хүргүүлсэн.